



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/133/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер: У.Оюунтүлхүүр	
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор: Э.Энхцэцэг	
		Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.01.28 № 1-6/199

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Г.ӨЛЗИЙБҮРЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

	Үзүүлэлт	2020.12.31	/төгрөгөөр/ 2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	115,350,191.80	128,469,623.91
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,244,373,694.17	1,206,849,315.97
	Нийт хөрөнгийн дүн	1,359,723,885.97	1,335,318,939.88
	Нийт өр төлбөрийн дүн	284,502.00	672,739.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,359,439,383.97	1,334,646,200.88
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,359,723,885.97	1,335,318,939.88
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	694,663,131.00	527,418,590.57
	Үйл ажиллагааны зардлын дүн	520,412,160.68	547,595,527.61
	Үйл ажиллагааны үр дүн	174,250,970.32	(20,176,937.09)
	Үйл ажиллагааны бус үр дүн	(189,620.00)	(3,311,580.00)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	174,061,350.32	23,488,517.09)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		1,363,992,160.96
	Тайлант оны үр дүн		-23,488,517.09
	Эцсийн үлдэгдэл		1,334,646,200.88
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	431,610,639.00	430,451,476.30
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	429,748,739.00	427,214,576.30
	Үйл ажиллагааны ЦМГ	1,861,900.00	3,236,900.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(1,861,900.00)	(3,236,900.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		357,186,887.30
	Урсгал зардал		357,186,887.30
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		357,186,887.30
	Улсын төсвөөс санхүүжих		330,863,000.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		26,323,887.30

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын бодлого, стратегийн хэрэгжилтийг хангах, асуудлыг холбогдох хуулийн хүрээнд зөв зохистой хэрэгжүүлэх, гэр бүлийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлж, тогтвортой байдлыг ханган, амьдралын чанарыг сайжруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд, залуучуудын эрх, хөгжил, хамгааллын үйл ажиллагаа.

Эрхэм зорилго: Хүүхэд залуучуудын эрх, хөгжил, хамгаалал, оролцоог хангах.

Алсын хараа: Дэвшилтэт соёл уламжлал, ёс заншил болон орчин үеийн онол арга зүй туршлагыг гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан, "Хүүхдийн ордон" бүхий материаллаг нөөцтэй, эрсдэлд өртсөн хүүхэд, гэр бүлд зөвлөн туслах, хамгаалах байртай, мэдлэг хандлага, ур чадвар бүхий тогтвортой боловсон хүчинтэй төрийн захиргааны мэргэжлийн байгууллага болон хөгжинө.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Ковид-19 цар тахал өвчинтэй холбоотой засгийн газрын тогтоол, шийдвэрүүд шинээр гарч хэрэгжсэн.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 355.8 сая төгрөгийн, зарлагын 6.4 сая төгрөгийн ажил гүйлгээ, хөрөнгө зарцуулах тухай 355.7 сая төгрөгийн 37 тушаалыг Шилэн дансны цахим системд бүрэн мэдээлсэн байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 5.9 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илрүүлснээс, 4.8 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 1.1 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа:

1. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1.3 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн ашиглах жилийг оруулаагүйгээс элэгдлийн зардал дутуу тооцсоныг залруулав.

2. Тайлант хугацаанд нэмэгдсэн 3 нэрийн 0.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 6 нэрийн 1.6 сая төгрөгийн бараа материалыг дансны ангиллын дагуу бүртгээгүй байсныг залруулав.

3. Аймгийн Татварын хэлтэстэй тооцоо нийлээгүйгээс цалингаас суутгасан ХХОАТ-ын 0.04 сая төгрөгийн өглөгийг дутуу тусгасныг залруулав.

4. Аймгийн Засаг даргын 2021.04.12-ны өдрийн А/207 захирамжаар дэмжлэгээр өгсөн 2.1 сая төгрөгийн, 3 нэрийн бараа материалыг тайланд тусгаагүй байсныг залруулав.

Төлбөрийн акт:

1. Тайлант хугацаанд тус сумын 23 иргэнтэй орон сууц түрээслүүлэх гэрээ байгуулж, 2021 онд нийт 11.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 10.0 сая төгрөгийг төвлөрүүлж, дутуу төвлөрүүлсэн 1.9 сая төгрөгийн түрээсийн орлогыг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, мөн тус орлогын орон нутагт төвлөрүүлэх 50 хувь болох 5.0 сая төгрөгөөс 2.9 сая төгрөгийг төвлөрүүлж, төвлөрүүлээгүй 2.1 сая төгрөгийг өглөгөөр тусгаж тайлагнаагүй байсан зөрчилд төлбөрийн акт тогтоов.

2. Засаг даргын нөөц сангаас нийт 32.9 сая төгрөгийг зарцуулснаас сумын ЗД-ын 2021.09.24-ний өдрийн А/131 захирамжаар аймгийн ОБГ-ын албан хаагчдын буудал, хоолны зардалд 0,3 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоов.байна.

Албан шаардлага:

1.Тайлант хугацаанд 1.1 сая төгрөгийг зардал хооронд шилжүүлэн, зориулалт бусаар зарцуулсан байна.

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан зааврын дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тухай албан шаардлага хүргүүлэв.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ГБХЗХГазар	1	1	-	-	1	-	-	-
	НИЙТ	1				1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ГБХЗХГазар	5	5.9	4	4.8	0	0	1	1.1	0	0
	НИЙТ	5	5.9	4	4.8	0	0	1	1.1	0	0